

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН  
АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ  
ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТЭД 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2026 оны 01 дүгээр сарын 28

Дугаар:

Улаанбаатар хот

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2025 оны биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын 2.4-т заасан урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээ тус бүрээр үнэлгээ хийж, үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

**ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН**

"Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025 оны арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100 хувийн гүйцэтгэлтэй буюу дээрх журмын 2.5.1-д заасны дагуу "бүрэн хангалттай" ангилалд хамаарч байна.

Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдээс 100 хувийн биелэлттэй хэрэгжсэн онцлох ажлуудаас дурдвал:

✓ Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар дотоодын 10 сургалтад 121 албан хаагч, гадаадын 53 сургалт, семинар, форум, бүсийн зөвлөгөөнд 64 албан хаагч, нийт 63 сургалтад давхардсан тоогоор 184 албан хаагчийг хамруулсан байна.

✓ Яамны болон салбарын албан хаагчдыг сургах, чадавхжуулах чиглэлээр сургалт, хөгжлийн үйл ажиллагааны хүрээнд Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч нарын сургалтад 19.8 сая төгрөг, Төрийн албан хаагчдыг чадавхжуулах Монгол бичгийн сургалтад 5 сая төгрөг, Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалтад 19.8 сая төгрөг, Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад- 2.3 сая төгрөг. Дээрх сургалтуудад нийт 46,900,000 төгрөг зарцуулсан байна.

✓ Албан хаагчдад шаардлагатай компьютер, тоног төхөөрөмж, программ хангамж, бичиг хэргийн материал авч, ая тухтай ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр засвар үйлчилгээг тухай бүр хийж, нийт 321,841,946 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тус яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр батлах тухай" А/85 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр", 2 дугаар хавсралтаар "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025 оны арга хэмжээний төлөвлөгөө"-г тус тус баталсан байна.

Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд үндсэн үйл ажиллагааны 4 зорилт, чиглэлийг тодорхойлж, тусгасан байна.

Мөн дээрх төлөвлөгөөг "Албан хаагчдын ажиллах нөхцөл, хангамжийг сайжруулах хүрээнд" (арга хэмжээний тоо 4) болон "Албан хаагчдын амьдралын нөхцөлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд" (арга хэмжээний тоо 5) гэсэн 2 хэсэгт хувааж, нийт 9 заалттайгаар төлөвлөжээ.

Түүнчлэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025 оны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 3 дугаар хавсралт дахь "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах хүснэгт"-ийн дагуу Зорилтот түвшин хэсэгт байгууллагын төлөвлөгөөнд тусгасан дүнг бичиж ирүүлсэн байна.

#### ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр батлах тухай" А/85 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр"-ийн 6.1-д "Хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхдээ албан хаагчдын оролцоог хангах боломжийг бүрдүүлнэ" гэж заасны дагуу тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх зорилгоор яамны албан хаагчдаас 9 асуулт бүхий судалгааг боловсруулж, мэдээлэл цуглуулсан.

Албан хаагчдаас авсан судалгааны дүнгээс үзэхэд 2025 оны арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилт чиглэл бүрээр харилцан адилгүй байна. Ажлын үр дүнг үнэлэх, урамшуулах, сургалт зохион байгуулах, спортыг дэмжих чиглэлд эерэг үр дүн гарсан боловч урамшуулал, тоног төхөөрөмжийн хангалт, мэдээллийн хүртээмж жигд бус байгааг албан хаагчид онцолжээ. Харин эрүүл мэндийн үзлэг, орон сууц, амьдрах нөхцөлийн дэмжлэг, мөнгөн тусламж олгох зэрэг нийгмийн баталгаатай холбоотой арга хэмжээнүүд төлөвлөгөөнд тусгагдсан хэдий ч бодит хэрэгжилт хангалтгүй, албан хаагчдын сэтгэл ханамж бага байгааг судалгааны дүн харуулж байна.

Мөн тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр батлах тухай" А/85 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр"-ийг баталсан боловч Төрийн албаны тухай хуулийн 55.3-т заасны дагуу албан хаагчдын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлаагүй байна.

Иймд хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг бүрэн хангаж сургалтын хөтөлбөр болон тухайн жилд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулах шаардлагатай байна.

Түүнчлэн цаашид хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах арга хэмжээг боловсруулахдаа байгууллагын нийт албан хаагчдын ар гэр, нийгмийн байдлыг хамарсан дэлгэрэнгүй судалгааг хөндлөнгийн, хараат бус байгууллагаар хийлгэж, уг судалгааны үр дүнд үндэслэн бодит хэрэгцээ, шаардлагад нийцсэн арга хэмжээг тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

#### ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ /ЗӨВЛӨМЖ/

“Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”-ийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг холбогдох хуульд заасны дагуу бүрэн боловсруулж оны эхэнд батлуулж хэвших;

2. Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, төсвийн саналаа яамны төсвийн төсөөлөлд хуулийн хугацаанд тусгуулах;

3. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тэдний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох дэлгэрэнгүй судалгааг гаргаж, судалгаанд үндэслэн үр дүнтэй ажлуудыг зохион байгуулах;

4. Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг улирал тутам хянаж, гарч буй хүндрэл, эрсдэлийг тухай бүр тодорхойлон засч сайжруулах арга хэмжээг авч ажиллах;

5. Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөөг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхой болгож, үр дүнг тайлагнах, үнэлэх тогтолцоог сайжруулах.

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ,  
АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ (2025 ОН)**

Д/д	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот	Хүрсэн	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан (дотоод сургалт)	1.1	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	7	8	<p>-Удирдлагын академийн 4 төрлийн сургалтад нийт 14 албан хаагч хамрагдсан.Үүнд:</p> <p>- Эрхэлсэн түшмэлийн багц цагийн сургалтад-1, ахлах түшмэлийн багц цагийн сургалтад-3 албан хаагч улсын төсвийн санхүүжилтээр, өөрийн зардлаар эрхэлсэн түшмэлийн багц цагийн сургалтад-3, ахлах түшмэлийн багц цагийн сургалтад -2 албан хаагч;</p> <p>-Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад-2 албан хаагч;</p> <p>-Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад-1 албан хаагч;</p> <p>-Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад-2 албан хаагч тус тус суралцаж, төгссөн.</p> <p>-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад 27 албан хаагчийг хамруулсанаас 4 албан хаагч шалгалтад хамрагдан тэнцэж, сертификат авсан.</p>
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	2	2	
			Мэргэшүүлэх сургалт	3	9	
			Туршлага солилцох арга хэмжээ	-	-	
			Бусад	-	3	
	1.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	121 (давхардсан тоогоор)		

		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	68	75	-Дэлхийн банкны Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт бүхий Худалдан авах ажиллагаа, Санхүүгийн удирдлага сэдэвт 3 өдрийн сургалтад-7 албан хаагч;
			Эрэгтэй албан хаагч	40	46	Дэлхийн банкны үйл ажиллагаа, санхүүгийн менежмент, худалдан авах ажиллагаа сэдэвт 3 өдрийн сургалтад -4 албан хаагч;
			Удирдах албан тушаалтан	10	12	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	100	109	-Төрийн болон нийслэлийн өмчит хуулийн этгээдэд төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлэх нь сэдэвт сургалтад-4 албан хаагч; - "Мэдээллийн технологи, хиймэл оюун ухааны хөгжлийн чиг хандлага" сэдэвт 1 өдрийн сургалтад 65 албан хаагч тус тус суралцаж, төгссөн.
		1.3	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	100 хувь	100 хувь	Хүрсэн үр дүн: Тайлант хугацаанд албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар дотоодын 10 сургалтад 121 албан хаагч, гадаадын 53 сургалт, семинар, форум, бүсийн зөвлөгөөнд 64 албан хаагч, нийт 63 сургалтад давхардсан тоогоор 184 албан хаагчийг хамруулсан байна. Хэрэгжилт 100 хувь
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын	2.1	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	32	53	1.Тайлант хугацаанд Япон, АНУ, Хятад, Арабын нэгдсэн Эмират, Энэтхэг, Португал, Малайз, Испани, Филиппин, Тайланд зэрэг улсад зохион байгуулагдсан 27 албан хаагч дараах 18 сэдэвт сургалтад хамрагдсан. Үүнд:

зардлаар хамруулсан (гадаад сургалт)	2.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	51	64	<ul style="list-style-type: none"> <li>-Жендерийн ялгааг арилгах, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хөдөлгөөнт холбооны архитекторын шийдэл боловсруулах;</li> <li>-Олон улсын аюулгүй байдал ба кибер орон зай дахь эмэгтэйчүүд;</li> <li>-5G сүлжээний радио спектрын менежмент болон хяналт;</li> <li>-Цахимжилтын эрин үед Мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан хүмүүсийн амьдралыг сайжруулах нь;</li> <li>-Санхүүгийн удирдлага ба дотоод аудит;</li> <li>-Дэд бүтцийн төсөл ба төр хувийн хэвшлийн түншлэл;</li> <li>-Цахим худалдаа;</li> <li>-Олон Улсын кибер дадлага сургуулилт;</li> <li>-Аюулгүй байдлын иж бүрэн хамтын ажиллагаа;</li> <li>-Цахим шилжилтийн асуудлаар чадавхыг бэхжүүлэх;</li> <li>- Ухаалаг хотын кибер аюулгүй байдлыг хангах нь;</li> <li>-НҮБ-Португалын сансрын тэтгэлэгт хөтөлбөр;</li> <li>-Тогтвортой хөгжлийн зорилтуудад зориулсан сансрын технологийн чадавхыг хөгжүүлэх ;</li> <li>-Азийн Номхон далайн бүс нутагт хиймэл оюун ухааны технологи ба стандартын чадавхыг бэхжүүлэх нь;</li> <li>-Урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг үр дүнтэй түгээх уян хатан дэд бүтэц”;</li> <li>-Цахим шилжилт;</li> <li>-Дэлхийн банкны дижитал эрүүл мэндийн төлөвлөгөө”;</li> <li>-Кибер аюулгүй байдлын сургалт;</li> <li>-Нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг түргэтгэхэд хиймэл оюун ухааныг үр ашигтай ашиглах нь;</li> <li>-Дэд бүтцийн төсөл ба төр хувийн хэвшлийн түншлэл;</li> <li>-Ерөнхий боловсролын сургуулиудыг харилцаа холбооны сүлжээнд холбох тогтвортой худалдан авалт;</li> <li>Хиймэл оюуны засаглалыг хэрэгжилт: Аюулгүй, инновацлаг тогтолцоог хөгжүүлэх нь.</li> <li>2. Швейцари, Япон, АНУ, Хятад, Энэтхэг, Португал, Малайз, Филиппин, Тайланд, Канад, Балба, Азербайжан</li> </ul>
	Үүнээс	Эмэгтэй албан хаагч	29	41	
		Эрэгтэй албан хаагч	22	23	<ul style="list-style-type: none"> <li>-Санхүүгийн удирдлага ба дотоод аудит;</li> <li>-Дэд бүтцийн төсөл ба төр хувийн хэвшлийн түншлэл;</li> <li>-Цахим худалдаа;</li> <li>-Олон Улсын кибер дадлага сургуулилт;</li> <li>-Аюулгүй байдлын иж бүрэн хамтын ажиллагаа;</li> <li>-Цахим шилжилтийн асуудлаар чадавхыг бэхжүүлэх;</li> <li>- Ухаалаг хотын кибер аюулгүй байдлыг хангах нь;</li> <li>-НҮБ-Португалын сансрын тэтгэлэгт хөтөлбөр;</li> <li>-Тогтвортой хөгжлийн зорилтуудад зориулсан сансрын технологийн чадавхыг хөгжүүлэх ;</li> <li>-Азийн Номхон далайн бүс нутагт хиймэл оюун ухааны технологи ба стандартын чадавхыг бэхжүүлэх нь;</li> <li>-Урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг үр дүнтэй түгээх уян хатан дэд бүтэц”;</li> <li>-Цахим шилжилт;</li> <li>-Дэлхийн банкны дижитал эрүүл мэндийн төлөвлөгөө”;</li> <li>-Кибер аюулгүй байдлын сургалт;</li> <li>-Нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг түргэтгэхэд хиймэл оюун ухааныг үр ашигтай ашиглах нь;</li> <li>-Дэд бүтцийн төсөл ба төр хувийн хэвшлийн түншлэл;</li> <li>-Ерөнхий боловсролын сургуулиудыг харилцаа холбооны сүлжээнд холбох тогтвортой худалдан авалт;</li> <li>Хиймэл оюуны засаглалыг хэрэгжилт: Аюулгүй, инновацлаг тогтолцоог хөгжүүлэх нь.</li> <li>2. Швейцари, Япон, АНУ, Хятад, Энэтхэг, Португал, Малайз, Филиппин, Тайланд, Канад, Балба, Азербайжан</li> </ul>
		Удирдах албан тушаалтан	10	13	
		Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	41	51	
	2.3	Гадаад сургалтад хамруулсан байдал:	10-аас дээш	18	

						<p>зэрэг улсад зохион байгуулагдсан 35 удаагийн форум, хурал, зөвлөгөөн, семинарт 37 албан хаагч оролцсон. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-PMAC 2025 чуулга уулзалт;</li> <li>-Дижитал Алматы-2025 форум;</li> <li>-Ази, Номхон далайн бүсийн Сайд нарын уулзалтад бэлтгэх 3 дугаар хурал;</li> <li>-Ази, Номхон-Далайн-Сансрын-Хамтын-Ажиллагааны Байгууллагын Хөгжлийн төлөвлөгөөний хурал;</li> <li>-Дэлхийн цахилгаан холбооны хөгжлийн бага хурал 2025-д бэлтгэх Ази, Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллагын 3 дугаар бэлтгэл хурал;</li> <li>-Дэлхийн цахилгаан холбооны хөгжлийн бага хурал 2025-д бэлтгэх Ази, Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллагын 4 дүгээр бэлтгэл хурал;</li> <li>-Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллагын Бүрэн эрхт төлөөлөгчдийн хурлын 1 дүгээр бэлтгэл хурал;</li> <li>-Ази, Номхон далайн бүсийн шуудангийн форум;</li> <li>-Дэлхийн Цахилгаан Холбооны хөгжлийн бага хуралд бэлтгэх Ази, Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллагын 3 дугаар бэлтгэл хурал;</li> <li>-Ази, Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллагын утасгүй холбооны багийн 34 дүгээр хурал;</li> <li>-Ази, Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллагын Бодлого төлөвлөлт, боловсруулалтын чиглэлээр дээд түвшний албан хаагчдад зориулсан семинар;</li> <li>-Аудитын комиссын хурал-2025" семинар;</li> <li>-CAIN 2025- Хиймэл оюуны инженерчлэлийн олон улсын семинар;</li> <li>-Цахим шилжилтийг эрчимжүүлэх бодлого, зохицуулалтын орчныг идэвхжүүлэх нь;</li> <li>-Хиймэл оюун ухааны чиглэлээр чадавхыг бэхжүүлэх;</li> <li>-Үндэсний хэмжээний өгөгдөл хамгаалах 8-р бага хурал;</li> </ul>
--	--	--	--	--	--	---

						<p>-Дижитал технологийн эрин үеийн манлайлал ба засаглал;  -Дижитал шилжилтийн цахим боловсрол: Ирээдүйг хамтдаа бүтээх нь  -Ази номхон далайн орнуудын дижитал шилжилт 2025;  -Гига холболтын форум;  -Дэлхийн радио холбооны их хурал (WRC27)-д бэлтгэх Ази, Номхон Далайн бүсийн 2-р бэлтгэл хурал;</p>
						<p>-Дэлхийн шуудангийн холбооны 28 дугаар конгресс;  -Дэлхийн Цахилгаан холбооны хөгжлийн бага хурал (WTDC-25)-д бэлтгэх Ази, Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллагын 5 дугаар бэлтгэл хурал;  -Админ байгууллагуудын 18 дугаар зөвлөлдөх уулзалт;  -Зүүн Азийн Хэлэлцүүлэг” болон "Talk China" семинар;  -Бодлого, зохицуулалтын 25 дугаар форум;  -Гамшгийн хор уршгийг арилгах, хариу арга хэмжээний механизм семинар;  -Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллагын Радио холбооны бүсийн семинар 2025” ба “Орчин үеийн Спектр Менежмент семинар;  -Олон улсын сансрын эрх зүй ба бодлого сэдэвт форум;  -Дэлхийн цахилгаан холбооны хөгжлийн бага хурал 2025;  -Удирдах зөвлөлийн 19 дүгээр хуралдаан” болон Манлайллын хөгжлийн форум;  -Ази, Номхон Далайн Орнуудын Сансрын Хамтын Ажиллагааны Байгууллагын Өгөгдөл хуваалцах платформын бодлогын баримт бичгийг боловсруулах шинжээчдийн анхдугаар уулзалт”.</p> <p>Хүрсэн үр дүн. Тайлант хугацаанд 18 удаагийн сургалтад 27, 35 удаагийн форум, зөвлөгөөн, семинарт 37, нийт 53 удаагийн гадаад сургалт, хурал зөвлөгөөнд давхардсан тоогоор 64 албан хаагчийг зохион байгуулагч талын зардлаар хамруулсан байна.</p>

					Хэрэгжилт-100 хувь
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал	3.1	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл	<p>Яамны болон салбарын албан хаагчдыг сургах, чадавхжуулах чиглэлээр сургалт, хөгжлийн үйл ажиллагааны чиглэлээр тайлант хугацаанд дараах 4 сургалтыг яамны албан хаагчид болон төрийн бусад байгууллагын албан хаагчдын дунд зохион байгуулсан. Үүнд:</p> <p>-Мэдээлэл, харилцаа-холбооны хяналтын улсын байцаагч нарын сургалтад- 19.8 сая төгрөг;  -Төрийн албан хаагчдыг чадавхжуулах Монгол бичгийн сургалтад 5 сая төгрөг;  -Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалтад -19.8 сая төгрөг;  -Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад- 2.3 сая.</p> <p>Хүрсэн үр дүн. Дээрх сургалтуудад нийт 46,900,000 төгрөг зарцуулсан.  Хэрэгжилт 90 хувь</p>	
4	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	4.1	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь (15%-аас доош байх)	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь 14,3 хувь	
		4.2	Шатлан дэвшүүлсэн албан хаагчийн тоо	7	<p>Тайлант хугацаанд яамны дараах төрийн жинхэнэ албан хаагчид Төрийн албаны тухай хууль болон холбогдох журмын дагуу шатлан дэвшиж, тусгай шалгалтаар нэр дэвшин томилогдсон. Үүнд:</p> <p>- Б.Эрдэнэ- Салбарын хүний нөөц, судалгааны хэлтсийн даргын албан тушаалд;  -Л.Нармандах- Гарааны бизнесийн экосистемийг дэмжих хэлтсийн Инновацийн дэд бүтэц хариуцсан шинжээч албан тушаалд;  -Д.Мөнхсарнай- Төрийн захиргааны удирдлагын газрын Тогтоол шийдвэрийн биелэлт, мэдээллийн ил тод байдлын асуудал хариуцсан шинжээчийн албан тушаалд;</p>

					<p>-С.Лхам- Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан хариуцсан шинжээч бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд;</p> <p>-Б.Нинж-Эрдэнэ. Салбарын хүний нөөц, судалгааны хэлтсийн Судалгаа, статистик, стандарт хариуцсан шинжээчийн албан тушаалд;</p> <p>-Б.Эрдэнэчимэг- Их өгөгдөл, хиймэл оюун ухааны хэлтсийн Гүн болон машин сургалт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд;</p> <p>-Э.Мөнгөнчимэг- Төрийн үйлчилгээний дахин загварчлалын хэлтсийн Салбар дундын зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтнээр дэвшүүлэн томилсон байна.</p>
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	7	
	Эрэгтэй албан хаагч		-		
	Удирдах албан тушаалтан		1		
	Гүйцэтгэх, туслах албан тушаалтан		6		

		4.3	Шилжүүлсэн болон сэлгэн ажиллуулсан албан хаагчийн тоо		<p>1. Дараах албан хаагчдыг Төрийн албаны тухай хуулийн 44.1 дэх заалтыг үндэслэн төрийн өөр байгууллагаас тус яаманд шилжүүлэн ажиллуулсан. Үүнд:</p> <p>- Үндэсний статистикийн хорооны Мэдээллийн технологийн газрын Программ хангамжийн хэлтсийн референтийн албан тушаалаас Т.Пүрэвсүрэнг Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлт хариуцсан ахлах шинжээчийн албан тушаалд;</p>
				5	<p>- Нийслэлийн Архивын газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргын албан тушаалаас Б.Загарсүрэнг Хүний нөөцийн асуудал, дотоод сургалт хариуцсан ахлах шинжээчийн албан тушаалд шилжүүлэн авсан.</p> <p>2. Дараах албан хаагчдыг өөрсдийн зөвшөөрөл, байгууллагын удирдлага хоорондын харилцан тохиролцсноор төрийн өөр байгууллагад шилжүүлсэн. Үүнд:</p> <p>- Тус яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Борхүүг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар;</p> <p>- Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөцийн асуудал, дотоод сургалт хариуцсан ахлах шинжээч Г. Өнөрхуягийг Соёл, спорт, залуучууд, аялал жуулчлалын яам;</p> <p>- Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Бат-Өлзийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам руу тус тус шилжүүлсэн.</p> <p>Хүрсэн үр дүн: Төрийн албаны тухай хууль, холбогдох журмын хүрээнд албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр-дүнг-үнэлж, урамшууллыг олгож, шилжилт хөдөлгөөнийг тухай бүр хийж, системд бүртгэж хэвшсэн. Хэрэгжилт: 100 хувь</p>
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	2	-
			Эрэгтэй албан хаагч	3	-

		Удирдах албан тушаалтан	2	-
		Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	3	-

НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

5.	Албан хаагчид олгосон цалин урамшуулал, нөхөх төлбөр, тусламж, дэмжлэг	-	<p>Тайлант оны гүйцэтгэлээр албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлс - 3,323,176,006.36 төгрөгийг зарцуулсан байна.</p> <p>-Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу удаан хугацаагаар өвчилсөн, шинээр гэр бүл болох, хүүхэдтэй болох, гэр бүлийн гишүүн нь нас барах зэрэг тохиолдолд нийт 8 албан хаагчид 4,249,000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгосон.</p> <p>-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын тушаалаар төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг 9 албан хаагчид шинээр, 13 албан хаагчид ахиулан олгосон.</p> <p>-Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/85 дугаар тушаалаар Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр, 2025 оны төлөвлөгөөг тус тус баталсан.</p> <p>-Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/322 дугаар тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмын шинэчлэн баталсан.</p> <p>-Төрийн нарийн бичгийн даргын 2025.10.15-ны өдрийн "Хоол, унааны нөхөх зардлыг шинэчлэн тогтоох тухай" А/290 дугаар тушаалаар өдрийн хоолны мөнгийг-37,000 төгрөг, унааны нөхөх зардлыг -3000 төгрөг болгон шинэчилсэн.</p> <p>-2025 онд 4 албан хаагчийг төрийн дээд одон медальд тодорхойлон шагнуулсан байна.</p>
----	--	---	--

			<p>-Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйл болон Албан хаагчийн хүсэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй 1 албан хаагчийг зайнаас цахимаар ажиллуулж байна.</p> <p>Хүрсэн үр дүн: Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу албан хаагчдын цалин хөлсийг хугацаанд нь олгож, албан хаагчдын зайнаас ажиллах, ажил амьдралын тэнцвэртэй байдлыг хангах чиглэлээр уян хатан ажлын зохицуулалтыг хийж, хоол, унааны нөхөх төлбөрийг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд тухай бүр тушаал гаргаж, олгож хэвшсэн. Хэрэгжилт: 100 хувь</p>	
5.1. Улирлын урамшуулал олгосон байдал	Нийт албан хаагчийн тоо	-	81	
	Урамшуулал олгосон албан хаагчийн тоо	-	Давхардсан тоогоор 132 (Төрийн албаны зөвлөлийн ЦХИХХЯ-ны дэргэдэх салбар зөвлөлийн гишүүд, Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшуулал)	
	Үүнээс	удирдах	-	21 (давхардсан тоогоор)
		гүйцэтгэх	-	111 (давхардсан тоогоор)
	Нийт олгосон урамшууллын хэмжээ		-	264,990,163.64 төгрөг
	Үүнээс	I улирал	-	-
		II улирал	-	65 албан хаагчид 137,604,900.00 төгрөг

		III улирал	-	-
		IV улирал	-	67 албан хаагчид 127,385,263.6 төгрөг
		Цалингийн нийт санд эзлэх хувь	-	Нийт цалингийн батлагдсан төсөвт урамшууллын эзлэх хувь -6,7% (Яамны 2025 оны батлагдсан цалингийн сан-3,899,122,600.00 төгрөг )
	<b>5.2.Нөхөх төлбөрт олгосон зардал, нийт:</b>	албан хаагчийн тоо	-	79 (давхардсан тоогоор)
		нөхөх төлбөрийн хэмжээ	-	64,383,775.80 төгрөг
	5.2.1.албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2)	албан хаагчийн тоо	-	79 (давхардсан тоогоор)
		нөхөх төлбөрийн хэмжээ		64,383,775.80 төгрөг
	5.2.2.албан ажлын хэрэгцээнд хувийн автомашин хэрэглэсний нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 3.2)	албан хаагчийн тоо	-	байхгүй
		нөхөх төлбөрийн хэмжээ		
	5.2.3.төрийн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд	албан хаагчийн тоо	-	байхгүй

учирсан хохирлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 5.1, 5.2)	нөхөх төлбөрийн хэмжээ	-	--
5.2.4.хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг, гадаад оронд эмчлүүлэх	албан хаагчийн тоо	-	байхгүй
зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд эмчилгээний зардлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 7.1)	нөхөх төлбөрийн хэмжээ	-	-
5.2.5.гадаад улс болон орон нутагт ажиллахаар томилогдсон төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 4.1)	албан хаагчийн тоо	-	
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	-
5.2.6.замын зардлыг нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 6.1)	албан хаагчийн тоо	--	байхгүй
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	-
5.3.бусад нөхөх төлбөрт олгосон зардал, нийт:	албан хаагчийн тоо	-	90 (давхардсан тоо)

		нөхөх төлбөрийн хэмжээ	-	482,217,000 төгрөг
	5.3.1.төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардал болон ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр	албан хаагчийн тоо	-	90 (давхардсан тоо)
	зорчсон нийтийн тээврийн унааны зардлын хэмжээ ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.2, 8.4)	нөхөх төлбөрийн хэмжээ	-	475,131,000.00 төгрөг
	5.3.2.ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно. ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.3)	албан хаагчийн тоо	-	5
		нөхөх төлбөрийн хэмжээ	-	1,500,000 төгрөг олгох тушаал батлагдсан ч Ерөнхий сайдын албан даалгаврын дагуу олгогдоогүй болно.
	5.3.3.төрийн албанаас түр чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчид тухайн албан хаагчийн албан тушаалын 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нөхөх төлбөр ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.5)	албан хаагчийн тоо	-	1 албан хаагч
		нөхөх төлбөрийн хэмжээ	-	5,586,000.00 төгрөгөөр тушаал батлагдсан Ерөнхий сайдын албан даалгаврын дагуу олгогдоогүй болно.
	5.3.4.Төрийн албан хаагчийг эрхэлсэн ажил, эзэмшсэн мэргэжлийн	албан хаагчийн тоо	-	байхгүй

<p>дагуу 180 хүртэл хоногийн хугацаагаар эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу төрийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэхэд түүний эрхэлж байгаа албан тушаалын цалинг олгоно. ("Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.6)</p>	<p>нөхөх төлбөрийн хэмжээ</p>		
<p><b>5.4.Төрийн албан хаагчид олгосон тусламж, нийт:</b></p>	<p>албан хаагчийн тоо</p>	-	-
	<p>нөхөх төлбөрийн хэмжээ</p>	-	-
<p>5.4.1.өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн албан хаагчид олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж</p>	<p>албан хаагчийн тоо</p>	-	байхгүй
	<p>нөхөх төлбөрийн хэмжээ</p>	-	-
<p>5.4.2.албан үүргээ гүйцэтгэх явцад амь нас хохирсон албан хаагчийн ар гэрт олгосон нэг удаагийн буцалтгүй тусламж</p>	<p>албан хаагчийн тоо</p>	-	байхгүй
	<p>нөхөх төлбөрийн хэмжээ</p>	-	-

5.5.төрийн албан хаагчийн нийтлэг баталгаанд зарцуулсан зардал, нийт:	албан хаагчийн тоо	-	1 албан хаагч
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	3,879,000.00 төгрөг
5.5.1.ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид 1.5 сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон	албан хаагчийн тоо	-	1 албан хаагч
	нөхөх төлбөрийн хэмжээ	-	3,879,000.00 төгрөг
5.5.2.орон байраар хангагдахад төрөөс үзүүлсэн дэмжлэг	албан хаагчийн тоо	-	байхгүй
	зарцуулсан хөрөнгийн хэмжээ	-	
5.5.3.албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг сайжруулахад зарцуулсан зардал	зарцуулсан хөрөнгийн хэмжээ	-	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөл, ажиллах орчныг сайжруулах чиглэлээр батлагдсан төсөвтөө багтаан, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дараах худалдан авалтуудыг зохион байгуулж, зарцуулсан. Үүнд: -Бичиг хэргийн материалд-29,818,236 төгрөг; -Аж ахуйн материал (гэрэл, дулаалга, утасны аппарат, ус, кофе, өрөөний цоож, хаяг)--112,351,109.8 төгрөг; -Бусад хангамжийн материал (ажлын хувцас, тоон гарын үсгийн төхөөрөмж, нэмэлт хэрэгсэл)-д 26,951,100 төгрөг; -Тоног төхөөрөмж (ухаалаг дэлгэц-4, видео ханын дэлгэц-3, агаар чийгшүүлэгч-3, нотебүүк-12, дэлгэц-10 ширхэг, айпад-20 ) худалдан авахад-120,988,000 төгрөг;

			<p>-Microsoft office 365- 89 ширхэг, антивирусын программ-100 ширхэгийг худалдан авахад-30,823,500 төгрөг; -Ариутгал халдваргүйжүүлэлтэд 910,000 төгрөг тус тус зарцуулжээ.</p> <p>Хүрсэн үр дүн: Албан хаагчдад шаардлагатай компьютер, тоног төхөөрөмж, программ хангамж, бичиг хэргийн материал авч, ая тухтай ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр засвар үйлчилгээг тухай бүр хийж, нийт 321,841,946 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Хэрэгжилт 100 хувь.</p>
5.5.4.албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг (жилд) 1-ээс дээш	албан хаагчийн тоо	-	<p>Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэгийг төсөв, санхүүжилтийн нөхцөл байдлаас хамааран 2 жил тутамд 1 хийх зохицуулалт хийсэн. Урьдчилан сэргийлэх үзлэгт шаардагдах санхүүжилт яамны 2025 оны төсөвт тусгагдаагүй, 2026 оны төсөвт тусгагдсан тул эхний улиралд багтаан үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулна.</p> <p>-Албан хаагчдын идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих зорилгоор долоо хоног бүрийн пүрэв гарагт спортоор хичээллэх боломжийг олгож, спорт заалны гэрээ хийсэн. Заалны түрээсийн төлбөрт 2025 онд 4,500,000 төгрөг зарцуулсан байна.</p> <p>-Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг Засгийн газрын шилжин явах цомын тэмцээнд хамт олноороо 5 төрлөөр бэлтгэж, амжилттай оролцсон. Тус яамны эмэгтэй шатрын баг "Алтан медаль" авч, амжилт гаргасан.</p> <p>Хүрсэн үр дүн.Хэрэгжилтгүй Хэрэгжилт. 0 хувь</p>
	зарцуулсан хөрөнгийн хэмжээ	-	

ТАНИЛЦСАН:  
ЦХИХХЯ-НЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАЖ, НЭГТГЭСЭН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦ,


Б.МЯГМАРНАРАН

СУРГАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ, ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ЗАГАРСҮРЭН

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Б.ДАВААСҮРЭН